



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

### Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны Конвер өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны Конвер өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,699,567 (арван хоёр сая зургаан ерэн есэн мянга таван зуун жаран долоо) төгрөгийн бүртгэлийн хавсралтад заасан үнэ бүхий хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны Конвер өрхийн эрүүл мэндийн төв (М.Мөнхжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 17 нэр төрлийн 10,735,567.00 (арван сая долоон зуун гучин таван мянга таван зуун жаран долоо) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтанд дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 5 нэр төрлийн 1,964,000.00 (нэг сая есөн зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 70,000.00 (далан мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 21,000.00 (хорин нэгэн мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны Конвер өрхийн эрүүл мэндийн төв (М.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В. Оюумаа* В. ОЮУМАА



1150500741

D: lac \BL.Tushaal.doc

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
 2024 оны ..... дугаар сарын .....-ны өдрийн  
 ..... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

СБД-ийн 12-р хорооны "Конвер" Өрхийн эрүүл мэндийн төв 2024 он

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХК-н шийдвэр
<b>Тавилга эд хогшил</b>										
1	Хэвлийн булчин чангалах төхөөрөмж	15	1	90,000	90,000	90,000.00	-	Эвдэрсэн	устгах	устгах
2	Дөрвөлжин хар сандал	10	2	63,400	126,800	126,800.00	-	Эвдэрсэн	устгах	устгах
3	Саарал 3 н нүдтэй шургуулага	10	1	100,000	100,000	100,000.00	-	Эвдэрсэн	устгах	устгах
4	Ком ширээ шар	11	1	393,000	393,000	393,000.00	-	Эвдэрсэн	устгах	10000
5	Номын тавиур	11	3	209,000	627,000	627,000.00	-	Эвдэрсэн	20,000	20000
6	Картны тавиур	11	1	319,000	319,000	319,000.00	-	Эвдэрсэн	устгах	20000
7	Цайны шүүгээ	11	1	215,000	215,000	215,000.00	-	Эвдэрсэн	устгах	устгах
<b>Тавилга эд хогшлын дүн</b>					<b>1,870,800</b>	<b>1,870,800</b>	-			<b>50000</b>
<b>Машин тоног төхөөрөмж</b>										
1	Ургийн доллар	9	1	242,000	242,000	242,000	-	Эвдэрсэн	устгах	устгах
2	Жин ба өндөр хэмжигч	10	1	103,299	103,299	103,299	-	Эвдэрсэн	устгах	устгах
3	Тохируулагч	8	1	58,608	58,608	58,608	-	Эвдэрсэн	устгах	устгах
4	Принтер samsung	3	1	391,000	391,000	391,000	-	Эвдэрсэн	устгах	устгах
5	Суурин компьютер dell	3	1	1,339,900	1,339,900	1,339,900	-	Эвдэрсэн	устгах	устгах
6	УВЧ аппарат	9	1	750,000	750,000	750,000	-	Эвдэрсэн	устгах	устгах
7	Хүчил төрөгч өтгөрүүлэгч	10	1	1,260,160	1,260,160	1,260,160	-	Эвдэрсэн	устгах	устгах
8	Нөөтбүүк	9	1	1,350,000	1,350,000	1,350,000	-	Эвдэрсэн	устгах	устгах
9	Гантөлийн ком	15	1	190,000	190,000	190,000	-	Эвдэрсэн	устгах	устгах
10	Хүчний дасгалын төхөөрөмж	15	1	435,000	435,000	435,000	-	Эвдэрсэн	20,000	20000
11	Нөөтбүүк Toshiba	11	1	1,149,900	1,149,900	1,149,900	-	Эвдэрсэн	устгах	устгах

